

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр, Лхагва гараг

	Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
	Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 5
	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6 - 26
1.	<i>Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	7 - 18
2.	<i>“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	19 - 20
3.	<i>Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	20 - 25
4.	<i>Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	25 - 26

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 04 дүгээр сарын 17-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 23 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Амартүвшин, Ж.Батсуурь, С.Ганбаатар, Ч.Хүрэлбаатар;
Чөлөөтэй: Л.Мөнхбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Өнөрболор, Ш.Раднаасэд.

Нэг.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Оёдлын салбарын нэгдсэн мэргэжлийн холбооны ерөнхийлөгч Ч.Энхзаяа, Оёдлын салбарын нэгдсэн мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал О.Сансархүү, “Грандлекс партнерс” компанийн хуульч Ж.Дамбасүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазар, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Т.Энхтүвшин, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг хойшлуулах санал гаргаж, уг хуулийн төслүүдийг хойшлуулахаар тогтов.

Хоёр. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “автомашины нүүрсэн яндан, нүүрсэн яндангийн хаягдал” гэснийг “автомашины нүүрсэн яндан, катализатор, тэдгээрийн эд анги, хаягдал, өөдөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга

П.Оюунцэцэг, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Васгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хэлэлцэх асуудлын дараалалд орсон Үндэсний аудитын газрын тайланг хаалттай горимоор хэлэлцэхээр тогтов.

Байнгын хорооны нээлттэй хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 59 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордны “Их засаг” танхим
14 цаг 23 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Цогт-Очирын Анандбазар гишүүн ирсэн байна, Хавдисламын Баделхан гишүүн байна, Жигжидийн Батжаргал гишүүн байна, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн байна, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн байна, Болдын Жавхлан гишүүн байна, Салдангийн Одонтуяа гишүүн байна, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн байна, Цэндийн Сандаг-Очир гишүүн байна.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн тул Төсвийн Байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Эхлээд дарааллаар нь танилцуулъя. Та бүхэнд.

Нэгдүгээрт, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Эцсийн хэлэлцүүлэг байгаа.

Хоёрдугаарт, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл. Анхны хэлэлцүүлэг байгаа.

Гуравдугаарт, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. Салдангийн Одонтуяа нарын 10 гишүүн өргөн мэдүүлсэн. 04 сарын 10-нд өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх асуудал байна.

Дөрөвдугаарт, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 03 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн. Тогтоолын төсөл байгаа.

Тавдугаарт, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл.

Даргын зөвлөлөөс хэлэлцэхийг нь дэмжсэнээр хэлэлцэгдэхээр Засгийн газраас өргөн мэдүүлсэн тухай хуулиуд байгаа.

Зургадугаарт, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл.

Мөн Засгийн газраас 04 сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн гэсэн ийм асуудал байна.

Долдугаарт, Аудитын газрын тайлан хэлэлцэн батлах гэсэн асуудлууд байна. Хэлэлцэх асуудлын жагсаалттай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэхээр байгаа.

Ажлын хэсгийн ахлагч байна уу?
Х.Булгантуяа гишүүнийг дуудъя.

Ажлын хэсгийн гишүүн
Х.Булгантуяа, Сангийн яам Б.Тэлмүүн.
Ажлын хэсгийн бүрэлдэхүүн байхгүй байгаа тул хойшлууллаа.

Ажлын хэсэг түр хойшлуулья.
Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Х.Булгантуяа сайд алга байна.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд байхгүй байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн.

Нэмэлт оруулах тухай хуулийн төслийг танилцуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн алга байна.

Энэ үүднээс нэгд болон хоёрт хэлэлцэх байсан Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг түр хойшлууллаа.

Ингээд гурав дахь асуудалдаа орьё.

Нэг.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

/Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2024.04.10-ны өдөр
өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Гаалийн тариф гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл Салдангийн Одонтуяа нарын 10 гишүүн өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх асуудал байгаа.

Ингээд энэ хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг төсөл санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа танилцуулна.

С.Одонтуяа гишүүнийг микрофонд урьж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулья.

С.Одонтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр Ж.Батжаргал,
Ж.Батсуурь, Б.Бейсен, С.Ганбаатар,
Д.Ганбат, Г.Ганболд, Ц.Туваан,
О.Цогтгэрэл, Т.Энхтүвшин нарын 10 гишүүн санаачилсан хууль байгаа.

Энэ хууль манай Үйлдвэржилтийн байнгын хороон дээр нэлээд олон жил яригдаж, олон тооцоо судалгаа хийж,

байгууллагуудтай, мэргэжлийн хүмүүстэй уулзаж ингэсээр байгаад бас бид хэд нэлээд цаг алдсан.

Тэгэхээр өнөөдөр энэ хуулийн гол асуудал юу юм бэ гэхээр бид өмнө нь байсан амжилтаасаа Монгол Улс маш их ухарсан байна.

2005 онд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 29.0 хувийг оёдлын салбар дангаараа бүрдүүлж байсан. Энэ салбарт 33 мянган оёдолчид ажиллаж байсан.

Ажилчдын 95, бараг 100 хувь эмэгтэйчүүд энэ ажлын байранд байсан.

Одоо энэ ажиллагсдын тоо буураад 4, 5 мянга хавьцаа л эргэлдэж байгаа юм.

Тэгэхээр энэ салбарт бид хөл дээр нь босгох юм бол дахиад өмнө байсан 33 мянган хүнийг ажлын байртай болгох боломж бүрдэж байгаа юм.

Тэгээд эрхэм гишүүдэд хоёр тоо л хэлье. Монгол Улс жилдээ 1.1 их наядын бэлэн хувцас өмсдөг.

Үүний ердөө 8 хувийг л Монгол Улс өөрөө дотроо оёж гаргадаг.

Тэгэхээр бидний 10 гишүүний санаачилсан хууль бол ядуурлын бууруулахад маш чухал үүрэгтэй, жижиг дунд үйлдвэр эрхэлдгийн дийлэнх нь оёдлын салбарынхан байгаа учраас гаалийн татвараас оёмол бүтээгдэхүүн хийх даавуу, туслах материалыг гаалийн татвараас чөлөөлөх хуулийн төслийг өргөн барьсан юм.

Энд Монголд үйлдвэрлэдэг даавуунаас бусад гэж заасан. Монголд

100 хувийн ноосон даавууг л үйлдвэрлэдэг ердөө 2 үйлдвэр л байгаа. Энэ үйлдвэрийнхэнтэй уулзахад эд нар өөрсдөө хангалттай дотоодын хэрэглэгчидтэй. Энэ үйлдвэрт ямар нэгэн сөрөг зүйл үүсэхгүй юм.

Тийм учраас бид олон жил Монголчууд үйлдвэрлэл хөгжүүлбэ гэж ярилаа. Өөрсдөө юмаа хийдэг больё гэж ярилаа. Ядаж хувцсаа өөрсдөө оёод өмсчихдөг больё гээд энэ хуулийг санаачилсан.

Өмнө нь урд хөршөөс орж ирж байгаа оёмол бүтээгдэхүүн үнэ хямд, өрсөлдөх боломжгүй байсан бол одоо урд хөршид эрчим хүчний үнэ өссөн, цалин өссөнтэй холбогдуулаад бэлэн бүтээгдэхүүний үнэ маш нэмэгдсэн байгаа.

Тийм учраас манай дотоодын үйлдвэрүүд үүнийг үйлдвэрлэх бүрэн боломжтой.

Зарим үйлдвэрүүд дээр очиход бид дотоодынхоо зах зээлийг дэлгүүрүүдээ дүүргэж чаддаггүй.

Энд бид өргөжүүлээд, төрөөс бодлогоор дэмжээд өгөх юм бол бид ажлын байрыг хэд ч хүртэл нэмэгдүүлэх боломжтой гэж манай оёдлын салбарын ажил олгогчид үздэг.

Тийм учраас би гишүүддээ энэ гаалийн татвар дээр шальтай мөнгө ордоггүй юм билээ. Судалгаа хийсэн. Зарим жил 1 тэрбум төгрөг, зарим жил 2 тэрбум төгрөг л ордог юм билээ.

Тэгэхээр энэ 1, 2 тэрбумыг олох гэж байж энэ том үйлдвэрлэлийн салбарыг өөд нь татахгүй байх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй.

Тийм учраас ядуурлын бууруулахад бид хэчнээн их наядаар зардаг. Ялангуяа манай эмэгтэйчүүд хол яваад ажиллаж чаддаггүй. Гэрийнхээ ойрхон ажиллах гэдэг. Сумдаа, хороо, дүүрэгтээ ажиллах гэдэг.

Тийм учраас эмэгтэйчүүдээс маш их өргөдөл, санал хүсэлт ирдэг.

Тийм учраас энэ дээр гишүүдийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Ялангуяа манайх Европын Холбоо руу олон мянган бүтээгдэхүүн гаргах эрх байдаг. 32 мянга билүү.

Энэ дээр цахилгаан товчнууд, бусад туслах материалууд, гаалийн татвараас чөлөөлөгдвөл бидний экспортод гаргадаг бүтээгдэхүүнүүд хямдрах ийм боломжтой юм.

Г.Тэмүүлэн: С.Одонтуяа гишүүнд баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу?

Ц.Анандбазар гишүүн. Ц.Анандбазар гишүүнээр тасаллаа. Микрофон өгөхөөсөө өмнө ажлын хэсгийг танилцуулъя.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсэгт Чулуунхуягийн Энхзаяа Оёдлын салбарын нэгдсэн мэргэжлийн холбооны ерөнхийлөгч, Очирбатын Сансархүү Оёдлын салбарын нэгдсэн мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал, Жанчивсэнгээгийн Дамбасүрэн “Грандлекс партнерс” компанийн хуульч, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Ингээд Ц.Анандбазар гишүүнд микрофон өгье.

Ц.Анандбазар: Их сайхан хуулийн сайн төсөл санаачилж байгаа юм байна.

С.Одонтуяа гишүүн манай Салдан гуай гэж маш сайхан хүний хүүхэд.

Д.Салдан гуай Монгол Улсын төлөвлөгөөний комиссыг ахалж байсан Монголын домог болсон хүмүүсийн нэг.

“Сайн хүний үр, сүүт гүүний унага” гэж аавынхаа шийрийг хатааж ажлын байр гаргах сайхан төсөл санаачилж байгаа юм байна. Дэмжиж байна.

Салдан гуайн номыг уншиж байхад нэг их сайхан үг байсан.

Тэр бол **1970-1985 онд** Монгол Улс **нэг сард нэг үйлдвэр ашиглалтад оруулж байсан** юм билээ.

Монгол Улс нэг үйлдвэр оруулах гэж 30 жил болоод барахгүй байгаа шүү дээ.

Одоо бидний үед нэг үйлдвэрийг нэг сард нухаж байсан, устгаж байсан түүх л байна.

Тэгээд **“үйлдвэр барья”** гэж үг хэлж байгаа нь маш сайхан байна. Дэмжиж байна.

Тэгээд үйлдвэрлэлийн үндсүүд юу байх вэ гэхээр ер нь малын гаралтай түүхий эд дээр суурилсан үйлдвэрүүд маш чухал байгаа юм.

Даавуу бол ноос үнэд оруулах ганц юм. Өнөөдөр би энэ төсөлтэй хамтатгаад малчдын хүлээгдэж байгаа хамгийн чухал нэг төсөл **“сүү, сүүн бүтээгдэхүүнийг үнэд оруулах”** төслийн асуудлаар хэлье гэж бодож байна.

Удахгүй өргөн барих гэж байгаа **“Бага үдийн сүү”** гэдэг төсөл байгаа.

Энэ “сүү” гэдэг төсөл эмэгтэйчүүдэд ажлын байр ихээр гаргах төсөл байгаа юм.

330 сумын сургуулийн бүх хүүхдэд 11 цагт 250 грамм сүү хөөрүүлж өгнө.

Өнөөдөр сайхан юм нь нийслэл Улаанбаатар хот маань сүү өгдөг болсон байна.

Япончууд их намхан улсууд байсан. Япончуудын судалгаагаар сүү ууж эхэлснээсээ хойш 15см өндөр болж өссөн гэсэн 5 жилийн судалгаа хүртэл байдаг юм байна.

Сүү бол кальц, кали маш өндөртэй ийм бүтээгдэхүүн байдаг.

Монголчууд **“дэлэнт мал дээшээ”** гэж хүндэлдэг атлаа сүүгээ эхээр нь явуулаад олон жил болж байна. Сүү сааж чадахгүй байна. Үүний шалтгаан нь сүүн дээр өгдөг урамшууллын асуудал байгаа юм.

2024 оны 01 сарын 01-нээс Хөдөө аж ахуйн яамнаас санал, санаачилгаар нэг литр сүүнд мянган төгрөг өгсөн урамшуулал байгаа. Үүнийг нэгдүгээрт 1500 төгрөг болгож нэмэгдүүлэх хэрэгтэй байна. 2025 оны 01 сарын 01-нээс.

Ингэх юм бол сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ орж сүүний үйлдвэр сэргэнэ.

70 сая малтай мөртлөө сүү гадаадаас импортолдог ийм улс дэлхийд байхгүй.

Ингээд 330 сумд нийт 750 мянган хүүхэд дунд сургуульд сурч байна. Энэ 750 мянган хүүхдэд 250 грамм сүү өгөх юм бол хоногт 187 мянга 500 литр сүү өгөгдөх юм.

187 мянга 500 литр сүүг 22 хоногоор үржвэл нийтдээ 4 сая 125 мянган литр сүү хүүхдийн эрүүл мэндийн төлөө олгоно.

Энэ хичээлийн шинэ жилийн 9 сард үржихээр 37 сая 125 мянган төгрөг сумдад олгох болж байгаа юм.

Энэ төсөл хоёр талын ач холбогдолтой.

Нэгдүгээрт, С.Одонтуяа гишүүний өргөн барьсан ажлын байр бий болгохыг сум болгонд 20-оос доошгүй үнээтэй айл ажилтай болно.

Дээр нь энэ 37 сая 125 мянган литр сүүний үнэ 60 тэрбум төгрөгийг сум болгонд хөрөнгө оруулалт болгож оруулах ийм боломжтой болж байгаа юм.

Тэгээд одоо манай сумдын хүүхдүүдийн шүд нь 80 хувь нь цоорхой, цооролттой байна. **“Caries”** гэж хэлдэг энэ “цооролтоос сэргийлэх” зүйл бол “сүү” байдаг.

Дээр нь энэ “бага үдийн хоол” хүүхдүүдийг хангаж чадахаа, цатгаж чадахаа болиод удаж байна.

Тэгэхээр одоо энэ ганц гаргалгаа нь **“Бага үдийн сүү”** өргөн бариад бүх сумдын хүүхдэд сүү өгөх юм бол нэгдүгээрт хүүхдүүд маань өлсөхгүй болно.

Хоёрдугаарт, сумын төвийн үнээтэй олон эмэгтэйчүүд ажлын байртай болох ийм боломжтой болж байгаа юм.

Тэгэхээр ийм төслийг өргөн барина. Та нар маань дэмжээрэй.

Энэ С.Одонтуяа гишүүний өргөн барьж байгаа саналыг дэмжиж байна.

Тэгээд зарчмын хувьд сүүний төслийг гишүүд маань дэмжиж, 2025 оны 01 сарын 01-нээс.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Ц.Анандбазар гишүүнд 1 минут нэмээд өгье.

Ц.Анандбазар: Монгол Улсын 330 сум, 21 аймгийн төвд байгаа үнээтэй бүх айлыг ажлын байртай болгож, хөдөө орон нутагт сурч байгаа 750 мянган хүүхдээ калыц, калигаар дутагдахгүй, шүд нь цоорохгүй болгож, эрүүл болгож, хулгай хийдэг мөнгөө хүүхдэдээ зориулъя гэсэн ийм хуулийн төсөл өргөн барьж байгаа.

Ингэх юм бол хүүхдэдээ зориулсан маш том зүйл болно.

“Үдийн хоол” гэдэг хөтөлбөрийн дараа өргөн барьж байгаа **“Үдийн сүү”** гэдэг их том хөтөлбөр болно.

Ялангуяа хөдөөгөөс дэвшиж байгаа гишүүд сайхан дэмжиж энэ хуулийг батлалцаарай гэдгийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ойлголоо.

Ц.Анандбазар гишүүн дэмжиж санал хэллээ.

Би нэг тодруулаад. Хууль санаачлагч болоод Засгийн газраас нэг тодруулж асуух асуудал байгаа юм.

Засгийн газрын хуралдааны тэмдэглэл сая 03 сарын 20-нд гарсан юм байна. Эндээс хэд хэдэн онцлох асуудлууд байна.

Яах вэ, бид мэдээж хувийн хэвшлийнхнийг болоод үндэсний аж ахуйн нэгж, байгууллагуудыг, тэр дундаа оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих нь зарчмын асуудал.

Энд Засгийн газрын хуралдааны тэмдэглэл дээр тусгасан асуудал нь нэг талдаа оёмол үйлдвэрийн үндсэн хөрөнгө болох үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх нь буюу шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн татвараас чөлөөлөх асуудлыг судалж үзэх нь зүйтэй байна.

Яагаад гэхээр оёмол бүтээгдэхүүний түүхий эдийн материалыг гаалийн татвараас чөлөөлөх нь яг үндсэндээ үйлдвэрлэгч нарын татварын ачааллыг бууруулахгүй. Тэр дундаа импортоор түүхий эдийг нь нийлүүлж байгаа, оруулж ирж байгаа дундын зуучлагч нарт илүү ашигтай байдлыг бий болгох, эргээд татвар санхүүгийн ачаалал нь яг бодит үр дүндээ, тухайн тэр үйлдвэрлэгч нартаа хүрэхгүй байх эрсдэл байна.

Тэгэхээр энэ бол хуулийн төслийн үндсэн зорилгыг хангахгүй. Ингээд оёмол болон сүлжмэл бэлэн бүтээгдэхүүний

экспортын хэмжээ нэмэгдэхгүй байх эрсдэлтэй байна гэдэг зүйлийг бичсэн байгаа юм.

Тэгэхээр Засгийн газрын хуралдааны тэмдэглэл бас ингэж гарсан байна. Дээрээс нь хуулийн төслийг тухайн жилийн Төсвийн тухай хуулийн хамт өргөн боловсруулна гэж заасантай нийцэхгүй байна гэсэн нэг ийм саналуудыг өгсөн байна.

Энэ дээр хууль санаачлагч маань юу гэж үзэж байна. Засгийн газар, Сангийн сайд байхгүй байна уу?

Тэгвэл Сангийн яамыг төлөөлөөд энд орж ирсэн ажлын хэсэг, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн дарга энэ дээр хариулаач.

Тэгээд яг энэ хуулийн зорилго маань өөрөө зөв зүйтэй байдаг.

Гэтэл бидний хүсэж байгаа, хүлээж байгаа үр дүн нь гарахгүй бол бас нэг үр дүнгүй хууль болчихдог. Дундын зүгээр зуучлагч нар гэдэг юм уу, импортлогч нар завших ийм үр дүн гарвал бас харамсалтай зүйл болох байх л гэсэн болгоомжлол байна. Энэ дээр нэг тайлбар өгчихье.

Т.Энхтүвшин гишүүн. Хууль санаачлагч Т.Энхтүвшин гишүүн.

Т.ЭНХТҮВШИН: Баярлалаа.

Тэгээд бид **“Аж үйлдвэрийн сэргэлт”**, аж үйлдвэрийг цаашид нэлээн хөгжүүлэх хэрэгтэй.

Ялангуяа хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр нэлээн томоохон хэмжээний эргэлт гарах зайлшгүй шаардлага бий болоод байгаа юм.

Хуучин оёдлын үйлдвэрүүдийг дэмжиж, импортын татвараас чөлөөлдөг байсан юм билээ.

Тэр үед нийтдээ 30 мянган хүн оёдлын салбарт ажиллаж, Монгол Улс дотоодынхоо хэрэгцээг бараг 60-аас 70 хувийг хангадаг тогтолцоотой байсан.

Харамсалтай нь сүүлийн 7, 8 жилийн хугацаанд эргүүлээд импортын татварыг тавьсан байж байгаа.

Үүнээс болоод нөгөө оёдлын үйлдвэрийн гол түүхий эд болсон даавуу, дагалдах хэрэгслүүд нь бүгд импортын татвар төлж орж ирдэг болсон.

Ингээд Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон бусад улстай өрсөлдөх бололцоо боломж байхгүй болсон.

Одоо яаж байна вэ гэхээр даавуун бүтээгдэхүүний дагалдах, туслах материалууд яаж орж ирж байна вэ гэвэл бүгд ганзагаар орж ирж байна. Ганзагаар. Нэг орж ирэхдээ л 2 боодол даавуу ч гэдэг юм уу, ингэж орж ирээд байгаа юм.

Тийм учраас үүнийг нээлттэй болгоё. Оёдлын салбарууд маань хил гаалиар орж ирэх ирэхдээ даавуун бүтээгдэхүүнээ яг ачаад орж ирдэг. Тэгээд импортын татвараас нь чөлөөлөөд явах бололцоо боломжийг л бий болгож өгөөч гэж бодож байгаа юм.

Ингэж чадах юм бол манай оёдлын салбар бусад улсуудтай өрсөлдөх бололцоо боломж байж байна. Ялангуяа бид сургуулийнхаа хүүхдийн формыг, цагаан цамцыг, биеийн тамирын хувцас хэрэгслийг, мөн дотооддоо тэр бусад төрлийн хувцсуудыг хийх бололцоо боломж байж байна.

Ялангуяа бид сургуулийнхаа хүүхдийн формыг, цагаан цамцыг, биеийн тамирын хувцас хэрэгслийг мөн дотооддоо Тэр бусад төрлийн хувцаснуудыг хийх бололцоо боломж байж байна.

Оросын Холбооны Улс болон Европын Холбооны хувцсыг Монгол Улсаас хангах ийм бололцоо боломж байж байгаа юм.

Маш олон ажлын байр бий болно. Ялангуяа 45-аас дээш насны эмэгтэйчүүд маань ихэнх нь ажилгүй байгаа юм. Одоо оёдлын салбар дээр хийсэн судалгаагаар оёдлын салбарт ажиллаж байгаа нийт ажилчдын бараг 90 гаруй хувь нь эмэгтэй хүмүүс байж байгаа юм.

Тэгэхээр энэ хүмүүс маань нэгдүгээрт ажлын байраар хангагдана.

Хоёр дахь асуудал ерөөсөө энэ оёдлын салбар дээр хөрөнгө оруулалт гээд айхтар юм шаарддаггүй. Байр нь байгаад, оёдлын машин, эсгүүрийн машин нь байх юм бол оёдлын үйлдвэр эрхлэх бүрэн бололцоо боломж нь байгаа юм.

Тийм учраас л импортын татварыг чөлөөлж өгч оёдлын салбарыг л дотооддоо бий болгож олон эмэгтэйчүүдийг л ажилтай, орлоготой болгох ийм бололцоо боломжоор хангаж өгөөч ээ гэж. Энэ бол томоохон хэмжээний эргэлт авчирна. Эргэлт авчирна.

Өнөөдөр Хятад Улсад байгаа, Вьетнам Улсад байгаа, Тайланд Улсад байгаа энэ оёдлын үйлдвэрийн салбарууд дээр манай Монгол Улсын оёдлын

үйлдвэрүүд маань өрсөд үлдэж чадахгүй байна шүү дээ.

Тэгээд энэ маань юутай холбоотой вэ гэхээр бид ерөөсөө л импортоор бүх төрлийн л тэр даавуу болон даавуун бүтээгдэхүүнээ авдагтай холбоотой.

Тэгээд ажлын байр нэмэгдэхгүй байна. Маш олон эмэгтэйчүүд ажилгүй байна. Мэргэжил гээд нэг их юм шаардахгүй. 45 хоног юм уу, 21 оны сургалт, дамжаанд суугаад ингээд оёдолчин болох бүрэн боломжтой байгаа.

Тийм учраас энэ дээр томоохон хэмжээний эргэлт гарна.

Дээр нь Монгол Улс руу орж ирж байгаа хувцас ч гэсэн багасаж, дотоодоосоо энэ оёдлын үйлдвэрүүд Монгол Улсаа хангах бололцоо боломж нээгдэнэ л гэж бид үзэж байгаа. Баярлалаа.

С.Одонтуяа гишүүн нэмээд хариулах юм уу.

Г.Тэмүүлэн: Сангийн яам нэмж хариулах уу? Б.Тэлмүүн дарга.

Саяын гол үндсэн хуулийн үзэл баримтлалтай холбоотой хүсэж хүлээж байгаа үр дүнтэй холбоотой асуудлаар ямар байр суурьтай байгаа бол? Засгийн газар. Ажлын хэсгийн 3 номер.

Б.Тэлмүүн: Сайн байцгаана уу. Г.Тэмүүлэн даргын асуултад хариулья.

Сангийн яам болон Засгийн газраас хөнгөн үйлдвэр болон бусад үйлдвэрлэлийг дэмжих энэ зарчим дээр бид бүрэн дэмжиж байгаа.

Гол асуудал маань яг энэ дэмжлэг өөрөө хэр оновчтой байх вэ гэдэг дээр бид саналаа өгсөн.

Энэ дээр хоёр асуудал байгаа. Нэгдүгээрт, бид өнгөрсөн жилүүдийн хугацаанд хүнс, хөдөө аж ахуй, малын гаралтай түүхий эд болон газар тариалангийн бусад үйлдвэрлэлийн салбарууд дээр дандаа тоног төхөөрөмж, үндсэн хөрөнгөтэй холбоотой дэмжлэгүүдийг үзүүлэх бодлого баримталж байгаа.

Тэгэхээр Засгийн газраас өгсөн санал бол яг энэ оёдлын үйлдвэрүүдтэй холбоотой тоног төхөөрөмжийн гаалийн татварыг, шинэ тоног төхөөрөмжийн татварыг хөнгөлөхийг дэмжиж байна.

Оёдлын үйлдвэрүүд маань өөрөө технологийн хувьд, үндсэн хөрөнгийн хувьд чадавх, чадамжийн хувьд дээшилж байж өрсөлдөх чадвар сайжирна гэж үзсэн.

Түүхий эдийг импортоор оруулахыг бид аль болох дэмжихгүй байх нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа.

Энэ дээр хоёр асуудал байгаа.

Нэгдүгээрт нь, түүхий эдийг бид их чөлөөлөөд байх юм бол нөгөө талдаа дотоодын бусад үйлдвэрүүддээ сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байгаа.

Тэгэхээр Ерөнхийлөгчийн санаачлаад явж байгаа энэ бусад үйлдвэрүүд дээр Сангийн яамнаас оролцоод явахад үйлдвэрүүд ерөнхийдөө түүхий эд үйлдвэрлэх чиглэлийн үйлдвэрүүд маань энэ дээр тийм сөрөг цохилт авах эрсдэлтэй.

Хоёр дахь асуудлын хувьд хуулийн үзэл баримтлалд туссан зорилт хангагдахгүй байх эрсдэлтэй гэж үзэж байгаа.

Сая Т.Энхтүвшин гишүүний хэлдгээр түүхий эд нь өөрөө энэ гаалийн татварын дэмжлэг нь яг үйлдвэрлэгч дээр очих уу, эсвэл дундын зуучлагч, дундын түүхий эдийн наймаачид дээр очих уу гэдэг үндсэн асуудал байгаа.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд гаалийн татвараас чөлөөлж ирсэн бидний жишгүүдээс авсан сургамжаар түүхий эдийг чөлөөлөх нь оновчгүй байдаг юм байна. Түүний оронд тоног төхөөрөмжийг бид дэмжих ёстой. Эргэлтийн болон хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлийн боломжуудыг гаргах ёстой гэсэн ийм байр суурь илэрхийлсэн.

Гурав дахь асуудлын хувьд, хуулийн төслийн үзэл баримтлал.

Сая хууль санаачлагчаас хэлж байгаа татвараас чөлөөлчихвөл нээлттэй болоод далд эдийн засаг буурна гэсэн энэ зорилт хангагдахгүй байх эрсдэлтэй.

Яагаад гэхээр НӨАТ-ын болон бусад татвар тэртээ тэргүй байж байгаа. Импортлогч нар бусад төрлийн бүх татварыг төлөх үүрэг нь хэвээрээ байгаа учраас гаалийн татвар чөлөөлөгдсөнөөр үүнтэй холбоотой далд эдийн засаг буураад ил болно гэсэн ийм хүлээлт эрсдэлтэй гэж үзсэн.

Хамгийн сүүлийн санал бол Улсын Их Хурлаас гаргах татварын хөнгөлөлт, чөлөөлөлт заавал дуусах хугацаатай байх ёстой гэж Засгийн газраас үзэж байгаа.

Энэ дээр бид тодорхой хугацаанд хэрэгжүүлээд үр дүнг нь үнэлдэг. Шаардлагатай бол сунгадаг, эсвэл хэлбэрийг нь өөрчлөх замаар хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн ийм саналыг өгсөн байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг нэмээд хариулья. С.Одонтуяа гишүүн. Хууль санаачлагч.

С.Одонтуяа: Тэгэхээр Сангийн сайд Б.Жавхлан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар даргын өрөөнд надад өөрөө хэлсэн.

Гаалийн татвараас чөлөөлөх энэ хуулийг дэмжиж байгаа.

Харин НӨАТ-ыг энэ удаа оролдохгүй байя. Олон юм зохицуулахгүйгээр. Ямар ч байсан эхлээд гаалийн татвараас чөлөөлье. Үүнийг манай яам дэмжиж байгаа гэж өөрөө хэлсэн.

Хоёрдугаарт, нийтэд нь энэ хуулийг хэлэлцэх эсэхээ дэмжчихвэл дараа ажлын хэсэг дээр нарийвчлаад гаргаж болно.

“Монголд үйлдвэрлэдэггүй даавуу”-г л манай хууль санаачлагчид татвараас чөлөөлье гээд байгаа байхгүй юу.

Тэр дундын зуучлагчид яагаад очих болсон юм бэ гэхээр өмнө нь гаалийн татвараас чөлөөлдөг байсан юмыг чөлөөлөхөө больчихсон байхгүй юу. Сүүлийн 7, 8 жил.

Тийм учраас далд эдийн засаг, ганзагын наймаачид руу ороод ганзагын наймаачид 2, 3 боодлоор нь оруулж

ирэхдээ дандаа татваргүй оруулаад ирдэг. Хувь хүн.

Тэгэхээр нөгөө үйлдвэрлэгч чинь аль болохоор хямд хүнээсээ л авах гэдэг.

Одоо энэ төрлөөр бид энэ далд эдийн засгаасаа ухраад, аль болохоор үйлдвэрүүд өөрсдөө даавуугаа оруулж ирдэг энэ систем рүү шилжих нь зүйтэй байгаа юм.

Тэгээд Вьетнам, Лаос улсуудаар бид яваад үзэхэд ерөөсөө л ядууралыг бууруулахад л хамгийн гол нь байсан.

Түүнээс биш баахан ухаантай юм яриад л, тэгвэл тэгнэ, ингэхгүй бол ингэхгүй гээд байхаар ерөөсөө ядуурал чинь буурахгүй байна, энэ салбар чинь өндийхгүй байна.

Тийм учраас **“Монголд үйлдвэрлэдэггүй даавуу”-г л гаалийн татвараас чөлөөлье** гээд байгаа юм л даа.

Бид энэ даавууг үйлдвэрлэлтлээ химийн үйлдвэр, янз янзын юм. Бид амжихгүй шүү дээ.

Тийм учраас ямар ч байсан эхлээд даавууг нь оруулаад ирье л гэсэн ийм зүйл ярьж байгаа.

Тэгээд би түрүүн хэлсэн. 33 мянган эмэгтэйчүүд ажлын байраар хангагддаг байсан салбарыг одоо 3, 4 мянга руу буулгачихсан. Энэ төр, засгийн бидний буруу бодлогын л юу шүү дээ.

Тийм учраас үүнийг гишүүд дэмжээд. Харин энэ 38.1.23 дээрээ ажлын хэсэг гаргаад гишүүд тэр тоног төхөөрөмжөө нэмж болж байна, эсвэл энэ үг, үсгийг засах. Энэ бол нээлттэй.

Сангийн яамны би тэр тодорхой хугацаатай байх ёстой гэдгийг бас бид дэмжиж болно. Энэ хугацаан дээр жишээлэхэд 10 жил ч юм уу, энэ салбар бостол хийгээд үзэх л хэрэгтэй гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Б.Тэлмүүн дарга нэмж тодруулах зүйл байгаа юм уу? 3 номер.

Б.Тэлмүүн: Баярлалаа. Нэг зүйл нэмж хэлэх гэсэн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс хөнгөн үйлдвэрийн салбарыг дэмжих том ажлын хэсэг гаргаад, Улсын Их Хурлын тогтоол, яг энэ салбарын асуудлыг цогцоор нь шийдэх гээд Ерөнхийлөгчийн Тамгын газар болон бусад бүх байгууллагуудаас орсон том ажлын хэсэг явж байгаа.

Энэ дээр зөвхөн татварын асуудал гэхээсээ илүү том үндсэн органик хуулиуд, дээрээс нь хөнгөлөлттэй зээл болон татварын болон бусад төрийн бусад урамшууллын багтаасан цогц арга хэмжээний төлөвлөгөө орох гээд ажлын хэсэг явж байгаа.

Тэгэхээр бидний санал энэ ажлын хэсэгтэй уялдуулаад, том энэ салбарын хөгжилтэй нь уялдуулаад үүнийг авч үзэх нь зүйтэй болов уу гэсэн ийм саналтай байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Нэрсийг авъя.

Ж.Батжаргал гишүүнээр тасаллаа. Х.Булгантуяа гишүүн үг хэлнэ.

Х.Булгантуяа: Энэ хуулийг дэмжиж байгаа юм.

Яах вэ, том хэмжээний реформыг хүлээх юм бол Сангийн яамныхан аягүй их цаг хугацаа орох байх.

Нэгдүгээрт, бид ямар ч байсан дотоодынхоо боловсон хүчнийг алдчихаас өмнө.

Хоёрдугаарт, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд, өрхийн бизнес эрхлэлтийг дэмжих хүрээнд энэ бол одоо бидний нэн тэргүүнд л хийх ёстой ажлуудын нэг.

Манай Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авч байгаа хүмүүс, ялангуяа энэ чиглэлийн оёдлын бизнес эрхлэхээр зээл авч байгаа хүмүүс маш их байдаг.

Гэтэл тоног төхөөрөмж нь үнэтэй, тэгээд түүхий эд нь үнэтэй.

Гэтэл урдаас орж ирж байгаа бэлэн бараа, бүтээгдэхүүнүүд нь заримдаа татвар төлөх ч үгүй орж ирээд байх юм бол бид өрсөлдөх ямар ч арга байхгүй шүү дээ гэж ярьдаг.

Үүнийгээ дагаад бид бас нэг судалгаа хийж үзсэн юм. Жишээлбэл, Г.Тэмүүлэн дарга аа. Формыг. Зөвхөн пиджакных нь оронд Монголоос ноосон цамц хийгээд хүүхдүүдэд. Одоо гурвалжин захтай ноосон цамц гаднын формд өмсдөг шүү дээ.

Ингэхэд л ерөөсөө манай ноосны салбар дотооддоо үйлдвэрлээд л босчихоор юм билээ. Худалдан авах

чадвар нь ийм олон сурагч байгаа юм чинь. Улсын хэмжээнд.

Ингээд жишээлбэл бид хөнгөн үйлдвэрлэлээ өөрснөө дэмжих бодлогоо дотооддоо явуулахгүй бол угаасаа болохгүй.

Тэгээд би бол тэр том ажлын хэсэг тэр том бодлогыг хүлээнэ гэх юм бол ахиад доор хаяж нэг жил болох байх.

Тэгээд цаг алдахгүй үүнийгээ шийдэх нь зүйтэй байх. Үүнийгээ дагаад зээл, бодлого юмнуудыг ирэх оны төсвөөс байдаг юм уу, төсвийн тодотголоос бид шийдээд явахад боломжтой гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Ж.Батжаргал гишүүн саналаа хэлье.

Ж.Батжаргал: Хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг нь дэмжихээд хэлэлцүүлгийн түвшинд анхаармаар юмнууд бидэнд байгаа.

Монголын хөдөө аж ахуйн салбарын, мал аж ахуйн салбарын ноос ноолуурын боловсруулалтын түвшнийг хэдүүлээ ахиулна л гэвэл ээрэх, сүлжих, нэхэх салбарт чинь яалт ч байхгүй орох орцуудаа бид оруулж ирэхээс өөр аргагүй болчхоод байгаа юм.

Ээрэх дээр голч утасны тухай асуудал.

Үүнийг бид шийдэхгүйгээр ямар ч боломжгүй.

Дээр нь бэлэн бүтээгдэхүүн хийнэ гэвэл наад цахилгаан товчноос чинь авхуулаад өчнөөн юм яригдана. Үүнийгээ бид ямархуу байдлаар шийдэх вэ?

Уг нь бид энэ ард иргэдийнхээ өдөр тутам өмсдөг хувцасны материалыг өөрсдөө хийдэгсэн бол энэ 380 хэдэн мянган малчид буюу тэр 200-аад мянган малчин өрх дотор чинь бараг жилдээ 6 сая метр даавуу өрхийн түвшинд бэлэн хувцас болоод гарчих бололцоо байгаа байхгүй юу.

Энэ талаасаа харах юм бол бид үнэхээрийн энэ хуулийг дэмжихээс өөр арга байхгүй. Мэдээж юм хоёр талтай.

Орж ирэх орц нь тодорхой зуучлалаар дамжихыг үгүйсгэхгүй.

Тэгээд тэрүүнийгээ бид яаж харин зөв зохицуулалтаа хийж хамгаалалт юмнуудаа хийх үү, барих уу гээд зүйлүүд бий.

Тэгэхээр ерөөсөө хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлбэ, хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүнийг үнэ цэнд оруулья л гэвэл боловсруулах түвшний үйлдвэрлэлийн хурдцыг нь бид нэмэгдүүлж байж сая үнэ цэнд орох тухай асуудал гарна.

Эргээд хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлж байж энэ улс орны чинь эдийн засгийн өсөлт дотоодын хэрэглээ хангагдах бололцоо экспортлогдоод байгаа нөгөө ажиллах хүч чинь нэг хэсэг нь дотроо ажил хөдөлмөрөө эрхлээд улс орныхоо хөгжил эдийн засагт тодорхой хувь нэмрээ оруулаад өөрөө өөрсдийнхөө амьдралыг өөд татаад амьдралын чанараа дээшлүүлээд явах бололцоо боломж нь бүрдэх юм.

Эдийн засгийн өгөөж өрх гэрт оруулья гэвэл хэд хэдэн том макро түвшний юм бариад суугаад байлгүй бас

ийм хэлбэрээр очиж болох юмнуудыг нь давхар дэмжихээс өөр аргагүй л байгаад.

Тийм учраас би хэлэлцэх эсэхийг нь дэмжихье.

Хэлэлцүүлгийн түвшинд хэдүүлээ дахиж нарийсгаж нэлээн сайн ярьж, улс үндэстнийхээ эрх ашиг, үйлдвэрийнхээ хөгжил, иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн юмнуудаа илүү зөв томъёолж суулгах талаасаа хаа хаанаасаа ярилцаж, ёстой оюун санаануудаа эвлүүлэн зүүж шийдлээ гаргах нь зөв байх л гэсэн бодолтой байна.

Г.Тэмүүлэн: Ж.Батжаргал гишүүн үг хэллээ.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна.

Сая Ж.Батжаргал гишүүний хэлж байгаа, Сангийн яамны барьж байгаа байр суурь энэ асуудлууд дээр бид хэлэлцүүлгийнх нь явцад хэрэв

дэмжигдэх тохиолдолд анхаарах асуудлууд байна гэдэг зүйл байна.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нь дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

54.5 хувиар дэмжигдлээ.

Ц.Анандбазар гишүүн дэмжсэнээр орох юм байна. Протоколд тэмдэглүүлбье.

Ингээд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа танилцуулна.

Ингээд хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа орцгооё.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг болон дагалдан гарах тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгүүд байгаа.

Ажлын хэсэг ажилласан гэж ойлгож байна.

Ажлын хэсгийн ахлагч Х.Булгантуяа гишүүний микрофоныг өгье.

Х.Булгантуяа: Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсэг ажилласан.

Улсын Их Хурлаас Их Хурлын дарга хэд хэдэн асуудалд ажиллах чиглэл өгсөн.

Үүнээс гадна “Татварын хөгжил дэвшил холбоо” төрийн бус байгууллагаас Улсын Их Хурлын даргад нээлттэй захидал ирж, энэ хууль дээр

дахиж ажиллах нь зүйтэй гэсэн нэлээн урт албан хүсэлт ирүүлсэн байсан.

Үүнийг мөн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэгт ирснийг Төсвийн байнгын хорооны дарга руу энэ хүсэлтүүд нь ирсэн.

“Татварын хөгжил дэвшил холбоо”-ноос 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр бас ийм албан хүсэлт ирүүлсэн байна.

Тэгээд үүнийг судалж, хуулийн төслийн хэлэлцүүлэгт бас тусгах гэсэн ийм үүрэг чиглэлүүдийг өгсөн.

Тэгээд ажлын хэсгийн хүрээнд дахиж ажиллах ийм хэрэгцээ шаардлага үүсэж байна аа, дарга аа.

Тэгэхээр өнөөдрийн асуудлаас хойшлуулаад дахиж ажиллах хэрэгцээтэй болгох шаардлагатай байгаа.

Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу, Байнгын хорооны даргаас өгсөн чиглэлийн дагуу, энэ

төрийн бус байгууллагынх нь хүсэлтийн дагуу.

Г.Тэмүүлэн: Ойлголоо.

Ажлын хэсгийн дарга Х.Булгантуяа сайд эцсийн хэлэлцүүлэг болоод тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийх энэ хоёр асуудал дээр ажлын хэсэг дахиж хуралдах, гүйцээн боловсруулах шаардлагатай байна гээд хойшлуулах саналыг гаргаж байна.

Энэ саналын дагуу хоёр болон гуравдугаар асуудлыг хойшлуулъя. /алх цохив/

Ажлын хэсэг гүйцээн боловсруулах болоод Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу, мөн маргаантай байгаа асуудлууд дээр ажлын хэсгийнхээ дэд түвшин болон ажлын хэсгийн түвшиндээ байр сууриудыг нэгтгэх талаар анхаарч ажиллахыг хүсье.

Ингээд дөрөвдүгээр асуудалдаа орцгооё.

Хоёр.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал

гаргах гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Надад нэг санал байгаа юм байна.

Бидний хувьд энэ тогтоолын төсөлтэй холбоотойгоор ажлын хэсэг болоод Байнгын хороон дээр Гаалийн ерөнхий газраас санал ирсэн байгаа.

Төслийн 1 дүгээр зүйлийн “автомашины нүүрсэн яндан, нүүрсэн яндангийн хаягдал” гэснийг “автомашины нүүрсэн яндан, катализатор, тэдгээрийн эд анги, хаягдал, өөдөс” гэж өөрчлөх гэж Гаалийн ерөнхий газраас Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж байгаатай холбоотой томьёоллын саналыг ирүүлсэн байна.

Ингээд зарчмын зөрүүтэй энэ саналаар санал хураалтыг явуулъя. Саяын уншсан томьёоллоор.

Дахиад танилцуулаадахъя.

Төслийн 1 дүгээр зүйл дээр болохоор нөгөө хориглох, экспортод гаргах бараа, бүтээгдэхүүн дээр “автомашины нүүрсэн яндан, нүүрсэн яндангийн хаягдал” гэж байсан юм.

“Нүүрсэн яндангийн хаягдал” гээд. Үүнийг мэргэжлийн байгууллага буюу Гаалийн ерөнхий газраас үзээд Та

бүхэн маань үүнийг Улсын Их Хурал дээр хэлэлцэх явцад “автомашины нүүрсэн яндан, катализатор” гэж нэрийг нь оруулаад, тэдгээрийн эд анги, хаягдал, өөдөс” гэж өөрчлөх гэдэг.

Тэгээд ийм байдлаар яг бүрэн бүтэн энэ нүүрсэн яндан болон түүнтэй холбогдолтой хаягдлуудыг гаргахыг хориглоё гэсэн ийм саналыг Гаалийн ерөнхий газраас өгсөн байна.

Саяын уншсан саналын томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Саяын уншсан саналын томьёоллоор дэмжье гэдэг саналаар санал хураалтыг явуулж байна. Гишүүд анхааралтай байгаарай.

54.5 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Х.Булгантуяа гишүүн танилцуулах уу? Х.Булгантуяа сайд танилцуулъя.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Дараагийн хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Гурав.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг танилцуулна.

С.Чинзориг сайдыг микрофонд урья.

С.Чинзориг: Байнгын хорооны гишүүдийн амгаланг айлтгая.

Манай улсад гепатитын вирусийн халдварын тархалт өндөр байгаагаас элэгний хатуурал, хорт хавдраар өвчлөгсөд болон нас баралтын түвшнээр дэлхийд их дээгүүр орж байна.

Тэр дундаа гепатитын “В”, “D” вирусийн хавсарсан халдварын 80 хувь нь элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдраар хүндэрдэг гэсэн ийм нотолгоо байна.

Манай улсад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 1995 онд хийсэн судалгаа, тооцооллоор манай улсад гепатитын “D” вирусийн халдвартай 60 гаруй мянган иргэн байх магадлалтай гэсэн тооцоолол байгаа.

Одоо “D” вирусийн эмчилгээ Оросын Холбооны Улсад **“Мирклудекс”** (Myrcludex B) гэдэг тариаг хийж байна.

Энэ бол бусад улс орнуудад худалдан борлуулах эрхгүй. Дотоодынхоо иргэдэд эмчилгээнд ашиглаж байгаа.

Америкийн Нэгдсэн Улсын **“GILEAD Sciences”** компанийн **“Булевиртид”** (Bulevirtide) эмийг Европын Холбоо бүртгэсэн. Эмчилгээнд хэрэглэж байна.

Манай улс энэ эмийг өнгөрсөн жил **“өнчин эмийн жагсаалт”**-д бүртгэсэн.

Бид иргэдээ элэгний “D” вирусийн халдварын эсрэг эмчилгээнд хамруулахын тулд Америкийн Нэгдсэн Улсын “GILEAD Sciences” компанитай “Булевиртид” эмийг Монголд оруулж эмчилгээнд ашиглах талаар хэд хэдэн удаагийн хэлцэл хийж, сайд цахимаар 2 удаа уулзалт хийж, Азийн бүс хариуцсан захиралтай 1 удаа хэлцэл хийсэн.

Одоо бид энэ үнийг бууруулах хэлцлийг үргэлжлүүлэн хийж байна.

Ирэх долоо хоногийн дөрөв дэх өдөр Эрүүл мэндийн сайд Америкийн Нэгдсэн Улс “GILEAD Sciences” компанитай дахин цахимаар уулзалт хийх чиглэлээр ажиллаж байна.

Манайд өнгөрсөн жил **“Элэг бүтэн Монгол”** хөтөлбөр хэрэгжүүлэх 13 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс одоо 7 тэрбум төгрөгийн үлдэгдэл байна. Энэ жилийн төсөвт туссан 7 тэрбум.

Ингээд нийтдээ 13 орчим тэрбум төгрөгөөр бид Америкийн Нэгдсэн Улстай үнийн хэлцэл амжилттай болоод үнийг нь буулгаж чадвал элэгний “D” вирусийн эмчилгээг эхлүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Тийм учраас сарын эмчилгээнийх нь зардал их өндөр учраас иргэдийг санхүүгийн ачааллаас хөнгөлөх зайлшгүй шаардлагатай байна.

Энэ хүрээндээ гаалийн албан татвараас чөлөөлөх болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийг боловсруулж Байнгын хороогоор хэлэлцүүлж байна.

Ингээд Байнгын хорооны гишүүд Та бүхнийг энэ хуулийн төслийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Пүрэвийн Оюунцэцэг Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Аюурзанын Өнөржаргал Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя.

Ж.Батжаргал гишүүнээр тасалъя.
Ж.Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Тийм. Гепатит вирусүүдтэй тэмцэх чиглэлээр олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа.

Тэр “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд “С”-тэй (HCV) тэмцэх үйл ажиллагаа нэлээн гайгүй үр дүнгээ өгсөн.

Бид үүнийг цааш нь илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэх ёстой юм гэж үзээд 2023 оны төсөв батлахдаа орж ирсэн мөнгөн дүнг нь нэмэгдүүлээд Улсын Их Хурал иргэдийнхээ эрүүл мэндийн төлөө гепатит “D” вирустэй тэмцэх үйл ажиллагааг өргөжүүлэе гээд 13.0 тэрбум төгрөгийн асуудлыг би шийдсэн шиг санадаг юм.

Үүний үр дүн гэж ер нь ямархуу юм, юу гарч байна вэ гэдэг нэг асуудал.

Хоёр дахь асуудал. Нэр заагаад ороод ирчихсэн юм билээ. Татвараас чөлөөлөхөөр.

Энэ харин одоо ямар байдаг юм бол оо? “Гепатит D”-тэй тэмцэх, түүний дарангуйлах үйлчилгээтэй эм, бүтээгдэхүүний гаалийн татварыг хөнгөлөх тухай яригдах ёстой юу? Эсвэл нэг компани нэг эмийн тухай юм хуулиар бид зохицуулж өгч болох билүү? Энэ одоо ер нь эрх зүй талаасаа юу гэж харагдаж байна вэ гэдэг зүйл.

Гурав дахь зүйл. Энэ яриад байгаа эм, био бэлдмэл өөрөө дэлхий нийтийн эмчилгээний үйл ажиллагаанд өргөн хүрээтэй ашиглагдаж, хамгийн үр дүнтэй байна гэсэн тэр л дүгнэлт, юуг үндэслээд байгаа юм байна л гэж ойлгоод байгаа.

Ер нь хэчнээн улс оронд яаж ашиглаад, ямар үр дүн гараад байгаа ийм эм, бүтээгдэхүүн юм бэ? Энэ гурав дээр нэг тодорхой хариулт аваадахъя.

Г.Тэмүүлэн: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.
С.Чинзориг сайд.

С.Чинзориг: Тийм. Ж.Батжаргал гишүүний асуултад хариулахад, одоо ер нь “D” вирусийн эмчилгээ дэлхий нийтэд яг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага бүртгэсэн эмчилгээ нь **пег-интерферон /Peg-Interferon (P-IFN)/** гээд эмчилгээ байгаа.

Тэгээд бид тэр 2023 онд батлагдсан төсвөөс энэ интерпреоныг иргэддээ төлбөргүйгээ хийе гээд 9.0 тэрбум төгрөгөөр нь интерфероныг худалдан авах тендер зарласан.

Үлдсэн мөнгөөр нь аймаг, орон нутгуудад энэ элэгний “D” вирусийг оношлох шинжилгээ хийх чадавх бэхжүүлэх чиглэлээр. Нөгөө талаасаа Халдварт өвчин судлалын үндэсний төв дээр “D” вирусийг оношлох, тоолох

Монгол Улсад байдаггүй ийм тоног төхөөрөмжийг авахаар зарцуулсан.

Иргэдийн зүгээс тэр интерфероны эмчилгээг гаж нөлөө нь өндөр байна гэсэн нэлээн үг хэл гаргасан учраас бид энэ эмийн худалдан авалтын үйл ажиллагааг түр зогсоочихсон байдалтай байх.

Хоёрдугаарт, хуулийн төсөлд оруулахдаа бид ганцхан тэр Америкийн Нэгдсэн Улсын “GILEAD Sciences” компанийн “Булевиртид” эм гэдгээр нь оруулж байгаа.

Сангийн яамтай бид нэлээн ярьсан. Яг тодорхой хугацаатай, тодорхой нэр бүтээгдэхүүн зааж оруулах нь зүйтэй гэсэн ийм зүйл.

Нөгөө талаас одоогоор Америкийн Нэгдсэн Улсын энэ эмээс өөр одоо тийм дэлхий нийтэд худалдаалагдаж эмчилгээ хийж байгаа асуудал байхгүй.

Гэхдээ энэ дээр бас гишүүдэд нэг зүйл хэлэхэд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага Америкийн Нэгдсэн Улсын “Булевиртид” эмийг одоогоор бүртгээгүй байгаа.

Гэхдээ Европын Холбоонд бүртгэгдсэн. Эмчилгээнд хэрэглэж байгаа асуудал байгаа.

Ямар ч байсан бид Америкийн “GILEAD Sciences” компанитай эмчилгээ Монголд эхлүүлбэ.

Сарынх нь эмчилгээний зардал асар их өндөр юм билээ. Ж.Батжаргал гишүүн ээ.

Европын Холбоонд бидэнд байгаа мэдээллээр сарын эмчилгээний зардал нь 10 мянган евро гэж байгаа юм.

Манайд анх энэ “GILEAD Sciences” компани санал болгохдоо сарын 2500 доллар гээд. Бид асар өндөр байна гээд. Одоогийн байдлаар 1500-гаар ярьж байгаа. Цаашдаа дахиад буулгах.

Ингээд үргэлжлүүлээд үнэ буулгах хэлэлцүүлэг явуулж байгаа.

Би энэ хууль оруулж байгаа нь бидний ярьдгаар сааль хураахаар сав хураа гэж Америкийн “GILEAD Sciences” компанитай хийж байгаа бидний үнийн хэлцэл үр дүнтэй болоод энэ эмийг Монголд оруулаад ирэх бол ядаж иргэддээ санхүүгийн дарамтаас чөлөөлөх, энэ татвараас чөлөөлсөн хуулийг нь батлуулчихсан байя гэсэн бодолтой байна.

Хоёрдугаарт, энэ хуулийг батлуулчих юм бол бас Америкийн Нэгдсэн Улсын үйлдвэртэй хийж байгаа бидний хэлэлцээнд ч гэсэн бас нэлээн нааштай үр дүн авчрах болов уу.

Засгийн газар нь, Их Хурал нь энэ эмчилгээг иргэддээ хийх, санхүүгийн дарамтаас чөлөөлөх эрмэлзэл асар их байгаа юм байна гэсэн ойлголтыг Америкийн талд өгөхөд нэлээн хэрэгтэй болов уу гээд энэ хоёр хуулийн төслийг оруулж ирээд байна.

Г.Тэмүүлэн: Ж.Батжаргал гишүүн нэмж тодруулъя. 1 минут өгье.

Ж.Батжаргал: Тийм. Хуульдаа бид Ерөнхий нэршлээрээ аваад, Засгийн газар тэр биткусаараа зохицуулж болохгүй байгаа юм уу? Үүнийг.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. С.Чинзориг сайд. Микрофон. Ажлын хэсгийн 3 номер.

П.Оюунцэцэг: Асуултад хариулъя. Би Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг байна.

Ерөнхийдөө “D” вирусийн эмчилгээн дээр гааль, НӨАТ-ын татвараас чөлөөлөх эм нь эмийнхээ нэршлээр ганцхан “Булевиртид” л байгаа.

Тэгэхээр яваандаа эмчилгээ их өргөн хүрээтэй болоод, эмийн нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдсэн тохиолдолд, хүртээмж илүү болоод эмийн үнэ буурах магадлалтай гэж үзэж байгаа учраас энэ удаагийнх дээрээ харьцангуй эмийн үнэ өндөртэй “Булевиртид” эмээ олон улсын нэршлээр нь оруулж ирж байгаа.

Одоо ганцхан энэ эм л байгаа. Өөр эм байхгүй байгаа.

Г.Тэмүүлэн: Хариулт хангалттай юу? Ж.Батжаргал дарга. Ойлголоо.

Зарчмын хувьд Засгийн газраас орж ирж байгаа гол энэ хүн амын өвчлөл, нас баралтай холбоотой гол үндсэн суурь шалтгаан энэ элэгний вирустэй холбоотой. Үүнийг сэргийлэх, халдварыг оношлох, эмчлэхтэй холбоотой асуудлыг хуулийнх нь төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байна.

Байнгын хорооноос дөнгөж сая Салдангийн Одонтуяа гишүүнээс өргөн барьсан хуулийн төслийг хэлэлцсэн.

Энэ дээр Засгийн газрын хуралдааны тэмдэглэл дээр ингэсэн байгаа.

Татварын хувь хэмжээнд өөрчлөлт оруулах, хөнгөлүүлэх, чөлөөлөх аливаа хуулийн төслүүд Татварын ерөнхий хуулийн 4.2-т татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь хэмжээ болон татварын суурийг буулгахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна гэж заасантай нийцэхгүй байна гээд Засгийн газраас ийм санал өгсөн байгаа.

Б.Тэлмүүн дарга ч гэсэн яг энэ асуудал дээр түрүүн байр сууриа илэрхийлсэн.

Тэгэхээр одоо энэ зарчмын хувьд Засгийн газраас өргөн барьж ирж байгаа хуулийн төсөл. Бид зарчмыг нь дэмжиж байгаа.

Гэхдээ ер нь тухайн төсвийн жил эхэлчихсэн байхад, төсөв батлагдсан байхад орж ирж байгаа. Гишүүн хууль санаачлах бүрэн эрхтэй. Гишүүн санаачилсан дээр ялгаатай, ялгаралтай ханддаг асуудлууд байж болох юм уу, болохгүй юм уу, эсвэл адилхан нэг зарчим үйлчлэх юм уу?

Энэ төсөвт ямар нэг нөлөөлөх асуудлууд мэдээж л байхгүй байх л даа.

Тэгэхдээ энэ дээр Засгийн газар яг яаж үзсэн юм? Саяын гишүүний санаачилсан хуулийн төсөл дээр Засгийн газрын байр суурь бол Б.Тэлмүүн дарга яг тийм байр суурийг илэрхийлсэн.

Засгийн газар болохоор шуурхай горимоор гээд татварыг хөнгөлөх, чөлөөлөх асуудлуудыг оруулж ирдэг. Энэ ер нь зарчим нь яг цаашдаа яаж явах юм бэ? Энэ дээр та хэд ер нь Засгийн газар яг ямар байр суурь баримталж байгаа юм?

Б.Тэлмүүн дарга асуултад хариулъя. 3 номер.

Б.Тэлмүүн: Байнгын хорооны даргын асуултад хариулъя.

Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн.

Энэ хуулийн хувьд татварын суурийг бууруулах, төсвийн орлого бууруулах үр нөлөөгүйгээр 2024 оны төсөвт энэ дээр орлого тооцогдоогүй.

Цоо шинээр Засгийн газар энэ ХӨСҮТ-тэй холбоотой орж ирэх энэ эм дээр орж ирсэн.

Бид яг татварын суурийг бууруулах, тооцож байсан орлого бууруулах хэмжээний үр нөлөөтэй татварын хуулиудыг бид төсвийн жилтэй уялдуулж авах ёстой гэдэг ийм байр суурьтай.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Санал хураалтыг явуулж эхэлье.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. /алх цохив/

54.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Х.Баделхан гишүүд Та танилцуулчих уу? Чуулган дээр. Х.Баделхан гишүүн танилцуулъя.

Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Дараагийн асуудалдаа орцгооё.

Дөрөв.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг танилцуулна.

С.Чинзориг: Элэгний “D” вирустэй иргэдэд эмчилгээ хийлгэх шаардлагатай байгаа Америкийн Нэгдсэн Улсын “GILEAD Sciences” компанийн “Булевиртид” эмийг худалдан авах хэлцэл хийж байгаа.

Энэ хүрээнд иргэдийг санхүүгийн дарамтаас чөлөөлөх үүднээс нэмэгдсэн

өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төсөл өргөн барьсан.

Ингээд гишүүдийг энэ хуулийн төслийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: С.Чинзориг сайдад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Гишүүд анхааралтай байгаарай. /алх цохив/

54.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд баярлалаа.

Дараагийн асуудалдаа орёе.

Аудитын газрын тайлан хэлэлцэх асуудал байгаа. Ажлын бүрэл ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулъя.

Хаалттай горимоор хэлэлцэх асуудал байгаа. Танилцуулах материалууд хаалттай горимоор орж ирсэн байгаа.

Хуралдаан 59 минут үргэлжилж, 15 цаг 22 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД